

УЛС ТӨРИЙН ХЯМРАЛЫГ ЗОХИЦУУЛАХ НЬ

Г.Туяагэрэл докторант

Товч утга: Улс төрийн хямралыг шийдвэрлэнэ гэдэг нь улс төрийн хямралын талаарх онолыг практикт ашиглах боломжийг судлах тухай асуудал юм.

Улс төрийн хямралыг шийдвэрлэх нь сэтгэл судлалын шинжлэх ухаанаас эхлээд олон улсын харилцааны онол хүртэлх олон шинжлэх ухааны онол, үзэл баримтлалыг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Гэхдээ энэ судалгааны ажлын хүрээнд хямралын нөхцөл байдлыг зохицуулах улс төрийн аспектыг авч үзэх болно.

Сүүлийн арван жилийн хугацаанд улс төрийн хямралыг шийдвэрлэх технологийн тухай асуудал нь мөргөлдөөн ба хямралын эсрэг менежмент гэдэг ойлголттой холбоотойгоор яригдсаар ирсэн байна. Улс төрийн хямралыг шийдвэрлэх тухай судалгааны ажил нь улс төрийн хямралын хавсарга судалгаанд багтдаг байна. Иймээс улс төрийн хямралыг шийдвэрлэх технологийн тухай асуудал нь орчин үед эрчимтэй хөгжиж байгаа салбарын тоонд орж байна. Улс төрийн мөргөлдөөн ба хямралыг хэрхэн шийдвэрлэх тухай асуудал нь өнөөдрийг хүртэл судлагдсаар байгаа нь энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлууд нь агуулгын хувьд харилцан нэгдмэл бус байгаа гэдгийг харуулж байна. Улс төрийн хямралыг шийдвэрлэх тухай асуудал нь улс төрийн хямралын далайц хэр өргөн байгааг, хямралын нөхцөлд системийн тогтвортой байдлыг хэрхэн хангах тухай, хямралын эсрэг авч хэрэгжүүлсэн бодлого ба үйл ажиллагаа хэр үр ашигтай байгааг тус тус харуулж байдаг.

Түлхүүр үг: Улс төрийн хямрал, улс төрийн хямралын технологи "Хямралыг шийдвэрлэх нь" гэдэг нэр томъёог 1962 оны Карибын хямралын үед АНУ-ын сайд асан Р.Макнамар анхлан томъёолсоноос хойш улс төрийн практик өргөн хэрэглэгдэх болжээ. Хямралыг шийдвэрлэх гэдэг ойлголтын цаана өөр хоорондоо үл тохирох талуудын ашиг сонирхолын зөрчлийг хэрхэн зохицуулах тухай асуудлыг авч үзсэн байдаг. Хямралыг хэрхэн шийдвэрлэх тухай асуудал нь нэг улс үндэстний биш дэлхийн шинжтэй глобаль асуудал юм.¹⁰⁶ Австралийн судлаач Ж.Ричардсон "хямралын дипломат арга"¹⁰⁷ гэдэг нэр томъёог анх гаргаж ирсэн байдаг бөгөөд энэ нь тухайн үед олон улсын харилцаан дахь хүндрэлийг багасгахад чиглэсэн арга хэмжээ мэтээр ойлгогддог байсан байна.

Улс төрийн хямралыг шийдвэрлэх үйл явцыг ойлгохын тулд юуны өмнө түүнтэй ойролцоо утгатай нэр томъёонуудыг авч үзэх хэрэгтэй юм. Учир нь улс төрийн хямралыг шийдвэрдэх үйл явцад дагалдан үүсдэг түүнтэй төстэй нэр томъёонууд нь харилцан адилгүй утгыг агуулж байдаг учраас тэдгээр нэр томъёонуудын хэрэглээ нь өөр байдаг байна.

Улс төрийн хямралыг шийдвэрлэх явцад "Conflict management", "Conflict resolution", "Issues management", "Crisis management", "Risk management" гэдэг нэр томъёонууд яригддаг. Эхний хоёр нэр томъёо нь улс төрийн мөргөлдөөнийг зохицуулахтай холбогдон үүсдэг харилцаанд хэрэглэгддэг бол сүүлийн хоёр нэр томъёог хямралыг шийдвэрлэх явцад үүсэх мэдээллийн урсгал түүнийг зохицуулах харилцааны асуудалд гол төлөв хэрэглэгддэг байна.

¹⁰⁶ Лебедева М.М. Политическое урегулирования конфликтов. М., 1999. с. 30

¹⁰⁷ Бэрон Р. Агрессия/ Р.Бэрон, Д. Ричардсон. М., 1997. с. 45

Эрсдэлийн коммуникаци (Risk communication) гэдэг нь системийн аюулгүй байдлыг хангах явцад үүсэх эрсдэлийн тухай мэдээллийн харилцааг зохицуулах удирдлага юм. Тиймээс эрсдэлийг удирдана гэдэг нь нэг талаас тухайн харилцаанд учирч болохуйц эрсдэлийг тогтоох, улмаар эрсдэлийн түвшин болон системд үзүүлэх нөлөөллийг тодорхойлсоны үндсэн дээр тухайн эрсдэлийг даван туулж зорилгод хүрэх бодлого арга хэрэгсэлийг авч хэрэгжүүлэх нөгөө талаас эрсдэлийн өмнө байгууллага хамт олны хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох явдал юм. Эрсдэлийг удирдах удирдлага нь байгууллагын гадаад орчинд нээлттэй аль эсхүл хаалттай байж болдог.¹⁰⁸

Улс төрийн хямралыг шийдвэрлэхдээ эрсдэлийг тооцоолж түүнийг удирдах нь үүссэн хямралын нөхцөл байдал, хямралын хэв шинжээс ихээхэн шалтгаалдаг байна. Гэхдээ эрсдэлийг удирдах, тооцоолох үйл явц нь хэрхэн өрнөж байгаагаас үл шалтгаалан эцсийн зорилго нь хямралт нөхцөл байдлыг богино хугацанд шийдвэрлэх, учирсан хохирлын хэмжээг бууруулах явдал байдаг.

Орчин үеийн шинжлэх ухаанд “асуудлын удирдлага (problem management)”, “хямралын удирдлага (crisis management)”, “хямралын эсрэг удирдлага (anti-crisis management)” гэсэн ойлголтууд ихээр яригдах болсон бөгөөд эдгээр нэр томъёонууд нь агуулгын хувьд харьцангуй ойролцоо утгатай байдаг. Мөн тэдгээрийн хэрэглээг нь аваад үзэхэд “хямралын удирдлага” гэх ойлголтыг судалгаа шинжилгээний ном зохиолд ихээхэн хэрэглэсэн байдаг. Харин “асуудлын удирдлага” гэх ойлголтын хэрэглээ нь түүнийг бодвол харьцангуй бага байгаа юм. Гэсэн хэдий ч хямралын ба асуудлын удирдлага гэх ойлголт нь хямралыг удирдах шийдвэрлэх үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой нэр томъёонууд болох нь тодорхой юм.

1976 онд судлаач Г.Чейс “асуудлын удирдлага (problem management)” гэсэн нэр томъёог анх хэрэглэсэн байдаг. Тэрээр асуудлын удирдлага гэх ойлголт нь ерөнхий удирдлагын шинжлэх ухааны нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үзээд байгууллагын ерөнхий бүтэц, дотоод нөөц бололцоон дээр тулгуурлан зорилгоо томъёолж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалан үлдэхийн тулд бүтцэд учирч болох эрсдэлийг тооцоолсоноор түүнийг бууруулахад чиглэсэн удирдлагыг боловсруулах тухай асуудал юм гэж тодорхойлсон байдаг. Тиймээс байгууллагад учрах эрсдэлийг үнэлэх, судлах зайлшгүй шаардлагатай юм. Иймээс асуудлын удирдлага нь удирдлагын ерөнхий бодлого дээр тулгуурлан дотоод нөөц бололцоог зөв тооцоолсны үндсэн дээр эрсдэлийг бууруулах стратеги төлөвлөгөө ба зөвлөмж гэсэн хоёр ойлголтыг агуулж байдаг.¹⁰⁹

Судлаач Ян Митрофф хямралыг судалсан 30 жилийн судалгааныхаа үр дүнд тулгуурлан 1982 онд хямралын удирдлага гэж юу болох түүний үр дагаврын талаар анх тодорхойлсон байдаг. Харин судлаач О.Лербингер хямралын удирдлага гэдгийг:

1. Хямрал болохоос өмнө нөхцөл байдлыг үнэлэх, удирдлагыг төлөвлөх;
2. Хямралын нөхцөл байдалд удирдлагын үйл ажиллагааг төлөвлөх;
3. Хямралын дараах нөхцөл байдалд бүтээн босгох үйл ажиллагааг удирдан төлөвлөх гэсэн үндсэн гурван шатны удирдлагаас бүрддэг гэж үзсэн байдаг.¹¹⁰

¹⁰⁸ Monstad T.H. Issues and crisis management: "same, same, same but different". Uppsala, 2003.p. 10

¹⁰⁹ Chase W.H. Issues management: Origins of the Future. Stamford, 1984. p. 15

¹¹⁰ Lerbinger O. The crisis manager: Facing risk and responsibility. Part III. Hillsdale. NJ, 1997. p.

Хэрвээ хямралын үйл явцыг хянаж удирдлах боломжтой гэж үзэх юм бол “хямралын удирдлага” гэдэг нь хямрал оролцогч талуудын үйл ажиллагаанд нөлөөлж эхлэхээс өмнө түүний учруулах эрсдэлийн хэмжээг бууруулах тухай бодлого үйл ажиллагаа байх ёстой юм. Мөн нөгөө талаас оролцогч талуудын үйл ажиллагаа, сонирхлын улмаас нийгэмд үүсэх нөхцөл байдлын талаарх олон нийтийн санаа бодлыг зөв удирдан чиглүүлэх тухай асуудал ч энд багтах юм. Хямралын талаар олон нийтийн санаа бодол төлөвшихөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал үүрэгтэй.

Хямралын удирдлагын чиглэлээр мэргэшсэн судлаач Е.Островский “Хямралын удирдлага гэдэг бол нэгэнт бий болчихсон хямралыг зөв залж чиглүүлэн удирдах удирдлага юм. Иймээс хямралын удирдлагын мэргэжилтэн нийгэмд байх зайлшгүй шаардлагатай юм. Тэд нар хямралыг загварчилж, хямрал үүссэний улмаас эмх замбараагүй байдалд орсон бүтцийг авран анагаагчид юм. Мөн тэд нар хямралыг дахин шинээр загварлагчид юм”¹¹¹ гэж дүгнэсэн байдаг.

Байгууллагын бүтцийн өөрчлөлтийн явцад өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүйн улмаас байгууллагын хөгжилд сөргөөр нөлөөлөх үзэл бодол, уур амьсгалыг хамт олны дунд үүсгэж байдаг хэсэг бүлэг хүмүүс байдаг. Бүлгийг өөрчлөхийн тулд эхлээд түүний гишүүдийн оюун санаанд энэхүү өөрчлөлтийг хийж тэднээр өөрчлөлтийг хүлээн зөвшөөрүүлэх хэрэгтэй байдаг. Өөрчлөлт эхлээд оюун санаанд хийгддэг. Тэгэхээр асуудлын удирдлага гэдэг нь бүлгийн хувьд бүтцийн өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа гишүүдийн санаа бодлыг өөрчилж, тэдний үзэл санааг тухайн өөрчлөлтийг талархан дэмжиж, хүлээн зөвшөөрч байгаа бусад гишүүдийн үзэл бодолтой нэгэн ижил болгох тухай асуудал юм. Эндээс үзэхэд асуудлын удирдлага гэдэг нь тухайн бүтцийг нэгдмэл нэг бүтэц болгон бүрдүүлж байдаг бүлгийн гишүүдийн зан байдлыг удирдах тухай асуудал гэдэг нь харагдаж байна. Нэг талаас асуудлын удирдлага гэдэг нь бүтцийн хөгжилд нөлөөлөх ирээдүйн нөхцөл байдлын талаарх хандлагыг урдчилан таамаглах боломж юм. Харин хямралын удирдлага гэдэг нь үүний эсрэгээр бүтцийн хөгжилд шууд нөлөөлж нэгэнт үүсчихсэн хямралын нөхцөл байдлыг шийдвэрлэх, зохицуулах бодлогын тухай асуудал юм. Иймээс хямралын удирдлагын тухай асуудал нь нэгэнт үүсчихсэн нөхцөл байдал дээр яригддаг учраас нэн даруй авч хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа байдаг бол асуудлын удирдлага гэдэг нь ирээдүйд үүсэх нөхцөл байдлын талаар үнэлгээ хийж байгаа учраас урт хугацаагаар төлөвлөсөн бодлого арга хэмжээ байдгаараа өөр хоорондоо ялгагддаг байна.

Хямралын эсрэг удирдлага гэдэг ойлголтыг Оросууд эдийн засгийн шинжлэх ухаанд анхлан хэрэглэсэн байдаг. Хямралын удирдлага гэдэг нэр томъёог эрх зүйчид, PR-ийн мэргэжилтэнүүд хэрэглэдэг. Хямралын эсрэг удирдлага гэдэг нь цэвэр эдийн засгийн шинжлэх ухааны ойлголт юм. Харин улс төрийн шинжлэх ухааны хувьд хямралын эсрэг удирдлага нь ямар утга агуулгатай болохыг ойлгохын тулд энэхүү нэр томъёог эдийн засгийн шинжлэх ухаанд хэрхэн тайлбарласан байдгийг авч үзэх хэрэгтэй болно.

Хямралын эсрэг удирдлага гэдэг нь удирдлагын тухай шинжлэх ухааны нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд энэ нь хямралын үүсгэсэн нөхцөл байдлыг зөөлрүүлэх, тухайн нөхцөлд бүтцийг урьчилан бэлдэх, хямралын үүсгэх сөрөг үр дагаврыг

¹¹¹ В защиту управленческой интуиции. Интервью с Ефимом Островским//Сообщение. 2001. №9. с. 6

бууруулах улмаар хямралын нөхцөл байдлаас бүтцийг гарган дахин түүнийг бүтээх бодлого үйл ажиллагаа юм.¹¹²

Зарим нэгэн судлаачид хямралын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь байгууллагын нөхцөл байдал хямралт байдалд орчихсон үед яригддаг учраас түүнийг үнэлж дүгнэх нь зөвхөн цаг хугацааны асуудал л байдаг гэж үзсэн байдаг. Тухайлбал судлаач Уткин Э.А. "Хямралын удирдлагын гарын авлага" номондоо "Хямралын эсрэг удирдлагын гол зүйл нь нь санхүүгийн байдал нь бүтцийн тогтвортой хөгжлийг хангахад хүрэлцэхээргүй болсон үед бүтцийн тогтвортой байдлыг хэрхэн хангах вэ гэдэг асуудал юм. Санхүүгийн ийм хүндрэлтэй байдалд өрийн тухай асуудал яригдаж эхлэх нь тодорхой боловч энэ тохиолдолд гол асуудал нь бүтцийг устгаж үгүй болгохгүйгээр хямралын дараа үүсэх шинэ нөхцөл байдалд бүтцийг дахин хэрхэн бүтээх вэ гэдэг юм"¹¹³ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Грязнов А.Г "Хямралын эсрэг удирдлага гэдэг нь байгууллагын дотоод болон гадаад нөөц бололцоон дээр тулгуурлан санхүү эдийн засгийн байдлаа тогтвортой хадгалж үүссэн хүнд нөхцлийг даван туулахын тулд менежментийн шинжлэх ухааны орчин үеийн дэвшилтэт технологи, онол аргазүй дээр суурилсан, бүтцийн олон талт шинжийг агуулсан бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа бүхий тухайн байгууллагын удирдлагын тогтолцоог хэлнэ"¹¹⁴ хэмээн тодорхойлсон байдаг байна.

Эдийн засаг, санхүүгийн мэргэжилтнүүд хямралын удирдлага бол өргөн агуулгатай ойлголт учраас үүссэн нөхцөл байдлыг хямралын удирдлагаар хангана гэдэг нь тухайн байгууллагын зүгээс санхүү эдийн засгийн тодорхой хэмжээний нөөц, боломж, удирдлагын тодорхой бүтэц хэм, хэмжээ гэх мэт процедурын шинжтэй олон зүйлийг шаарддаг хэмээн үзсэн байдаг.

Хямралын эсрэг удирдлагаар мэргэшсэн судлаачид судалгаандаа CP, CC, CR, CA, CM, CP гэх мэт товчлон бичсэн үгнүүдийг өргөнөөр хэрэглэсэн байдаг.

CP- crisis planning буюу хямралы төлөвлөлт: Хямрал үүсэхээс өмнө хямрал бий болсон тохиолдолд учирч болох сөрөг үр дагавар, хямрал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл, эрсдэл, түүнийг гэтлэн давах боломжийг урьдчилан таамаглаж ажлын төлөвлөгөөг гаргах

CC- crisis controlling буюу хямралыг хяналт: Хямрал болохоос өмнө хямрал үүсэхэд хүргэх урьдач хүчин зүйлийг тооцоолох, нөхцөл байдлыг үнэлэх

CA- crisis action буюу хямралын үйл явц: Хямралын урьдач нөхцлийг тооцоолох

CR- crisis reaction буюу хямралын хариу үйлдэл: Нэгэнт үүссэн хямралт нөхцөл байдлын нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, шинэ нөхцөлд хуучин бүтцийг дахин сэргээн бий болгох.

Эдгээр нэр томъёонуудыг хямралын эсрэг менежментийн асуудлын хүрээнд хамааруулан авч үздэг байна. ACP (anticrisis planning), ACC (anticrisis controlling), ACA (anticrisis action), ACR (anticrisis reaction) гэсэн холбоо үгнүүдийг хямралын эсрэг удирдлагын хүрээнд хэрэглэдэг байна. ACP буюу хямралын эсрэг төлөвлөлт гэдэг нь хямрал үүсэхээс өмнө хямрал бий болоход нөлөөлөх урьдач хүчин зүйлийг тооцоолоход хэрэглэгддэг ойлголт юм. Харин ACC буюу хямралын эсрэг төлөвлөлт гэдэг нь хямрал үүсэхэд хүргэж байгаа нөхцөл байдлыг үнэлэхэд, ACA буюу хямралын эсрэг үйл явц гэдэг нь нэгэнт үүсчихсэн хямралын үед өрнөж байгаа өөрчлөлтийн сөрөг үйл явцыг саармагжуулахад, ACR буюу хямралын эсрэг хариу

¹¹² Зоидов К.Х. Кризисная цикличность и методология антикризисного регулирования переходной экономики России//Экономическая наука современной России. 2001. №2. с. 97

¹¹³ Уткин Э.А. Справочник кризисного управляющего. М., 1999. с. 23

¹¹⁴ Грязнов А.Г. Антикризисный менеджмент. М., 1999. с. 15

үйлдэл гэдэгт нэгэнт үүсчихсэн хямралаас бий болох сөрөг үр дагаврыг бууруулан бүтцийг хямралаас өмнө байсан хуучин хэв маягт оруулахад тус тус хэрэглэгддэг байна.¹¹⁵

Барууны улс төрийн шинжлэх ухаанд хямралын эсрэг удирдлага, хямралын хэрхэн шийдвэрлэх тухай асуудал нь удирдлагын шинжлэх ухааны нэгэн бүрэлдэхүүн гэж үздэг бол Оросын эрдэмтэдийн хямралын эсрэг удирдлага гэдгийг хямралын нөхцөлд зөвхөн зээлийн хүндрэлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх бодлого арга хэмжээ авах биш харин ч хямралыг даван туулахад зайлшгүй шаардлагатай санхүүгийн болоод эрхзүйн арга хэрэгслийг агуулсан эрхзүй, эдийн засгийн шинжлэх ухааны биеэ даасан салбар гэж үздэг байна.

Эдийн засгийн болоод нийгмийн хямрал нь шууд бус байдлаар улс төрийн амьдралд нөлөөлснөөр улс төрийн хямралыг үүсгэх нь бий. Эдийн засгийн болоод нийгмийн хямрал нь улс төрийн системийн тогтвортой байдалд болон засаглалын бүтцэд сөргөөр нөлөөлсөнөөр шууд бусаар улс төрийн хямралыг үүсгэж байдаг гэсэн үг юм. Хямралын эсрэг удирдлага гэдэг нь улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн хямралтай тэмцэх арга хэмжээний хүрээнд яригддаг байна. Гэтэл энэ нэр томъёо нь зөвхөн нэгэнт үүсчихсэн хямралтай тэмцэх үйл ажиллагаагаар хязгаарлагддаггүй харин ч хямралын нөхцөл байдалд улс төрийн элит болон улс төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хоорондын зөв зохицлыг хангаснаар улс төрийн системийн тогтвортой байдлыг хангах, хямралын нөхцөл байдлыг үнэлэх, улс төрийн системд хямралын дүн шинжилгээ хийх, хямралын эсрэг удирдлагын төлөвлөгөө гаргах зэрэг маш өргөн үйл ажиллагааг багтаасан ерөнхий ойлголт юм. Тийм ч учраас улс төрийн хямралыг хэрхэн үр дүнтэй зохицуулах, түүнийг шийдвэрлэх талаар өргөн хэмжээний судалгаа шинжилгээний ажлыг хийх зайлшгүй шаардлагатай байгаа юм. Улс төрийн хямралын эсрэг удирдлагын талаар судалгаа хийх шаардлагатай байна. Учир нь:

1. Хямралын эсрэг удирдлага гэдэг нь маш өргөн агуулгатай ерөнхий ойлголт байдгийн нэгэн адил улс төрийн хямралыг зохицуулна гэдэг нь тэр хэмжээгээрээ өргөн агуулгатай юм.
2. Улс төрийн хямралыг шийдвэрлэхэд цаг хугацааны хийгээд оролцогчидын тоо хязгаарлагдмал байдаг. Улс төрийн хямралт нөхцөл байдлыг даван туулах түүнийг шийдвэрлэх үйл ажиллагааг удирдлагаар хангах нь тодорхой цаг хугацаанд л үйлчилдэг, хэрвээ тэр цаг хугацаа нь өнгөрсөн л бол тэр удирдлагын үйл ажиллагаа хичнээн үр ашигтай байсан ч хэрэггүй зүйл болон хувирдаг. Нөгөө талаас улс төрийн хямрал нь зөвхөн нэг оролцогчтойгоор ч өрнөж болдог үзэгдэл юм. Ийм учраас улс төрийн хямралыг шийдвэрлэнэ гэдэг нь удирдлагаас уян хатан шинжийг шаарддагийн зэрэгцээгээр дотоод зохион байгуулалт нөөц бололцоог шаарддаг байна.
3. Улс төрийн хямралыг хэрхэн шийдвэрлэх талаарх судалгааны ажил нь зөвхөн эдийн засгийн хямралын эсрэг удирдлагын аргазүй дээр суурилаад зогсохгүй улс төрийн мөргөлдөөний онол, олон улсын харилцаа болон олон нийттэй харилцах харилцааны онол арга зүй дээр суурилан хийгддэг.

Улс төрийн хямралыг шийдвэрлэнэ гэдэг нь нэгэнт үүсчихсэн хямралыг хэрхэх тухай мөн хямрал үүсэхэд ойрхон болчихсон тийм нөхцөл байдалд ямар арга хэмжээ авах тухай асуудал юм. Тиймээс улс төрийн хямралын эсрэг удирдлагын зорилго нь:

¹¹⁵ Афанасьева Е. Кризисом управлять можно, если это делают профессионалы//Советник. 1999. №3. с.51

1. Улс төрийн систем, байгууллага болоод нийгмийн эмх замбараагүй байдлыг шийдвэрлэн дэг журамд оруулах
2. Улс төрийн системийн болоод улс төрийн байгууллагын тогтвортой байдлыг хангах бодлого үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх
3. Цаг хугацаа хүрэлцээгүй байгаа нөхцөлд үүссэн нөхцөл байдлыг шийдвэрлэх арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэх
4. Хямралын сөрөг үр дагаврыг бууруулсанаар нөхцөл байдлыг тайван байдалд шилжүүлэх явдал юм.

Улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн хямралыг шийдвэрлэх ба зохицуулах гэдэг нь хоёр өөр утгыг агуулж байдаг байна. Улс төрийн хямралыг зохицуулна гэдэг нь олон улсын болоод тухайн улсын дотоодод хэрэгждэг эрхзүйн хэм хэмжээний тусламжтайгаар хямралын түвшинг хэрхэн бууруулах тухай асуудал юм. Тэгэхээр улс төрийн хямралыг зохицуулсанаар нэг бол улс төрийн хямралын асуудал бүрэн шийдэгдэж дуусгавар болно эсхүл хямралын нөхцөл байдал царцанги байдалд орсоноор системийн үйл ажиллагаа тайван байдалд өрнөх боломжтой болно гэсэн үг юм. Гэхдээ царцанги байдалд орно гэдэг нь хямралын нөхцөл байдал нэг мөр шийдвэрлэгдсэн гэсэн үг биш юм.

Улс төрийн хямралын бодит нөхцөл байдлын тухай ярихын тулд хямралын үйл явц хийгээд түүнд оролцогч талуудаас эхлүүлээд хямралын үеийн технологийн асуудал улмаар улс төрийн хямралын эсрэг удирдлагын тухай авч үзэх хэрэгтэй юм. Ингэхийн тулд бид улс төрийн хямралыг зохицуулах үйл явц, улс төрийн хямралыг шийдвэрлэх технологи гэсэн ойлголтуудыг ялган авч үзэх хэрэгтэй юм. Улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн хямралын технологийн асуудал ихээр яригддаг. Технологи гэдэг ойлголтын цаана системийг бүрдүүлэгч элементүүдийн хоорондын зохицолыг авч үздэг ба энэ нь зорилго-хэм хэмжээ-арга хэрэгсэл-үйлдэл буюу үйл ажиллагаа-сэдэл гэсэн бүтэцтэй байдаг байна.

Улс төрийн технологи гэдэг нь улс төрийн системийн зорилгодоо хүрэх мөн системийн үр ашигтай байдлыг хангахад чиглэсэн арга хэрэгсэл хэм хэмжээний нэгдлийг хэлдэг байна. Улс төрийн системд дэвшүүлэн тавьсан зорилгодоо богино хугацаанд хүрч хүрсэн үр дүн, үйл ажиллагааны үр ашигтай байдлаа удаан хугацаанд хадгалан үлдэхийн тулд үр ашигтай улс төрийн технологи зайлшгүй шаардлагатай юм. Улс төрийн технологийн агуулга нь богино хугацаанд өндөр үр дүнг бий болгож түүнийгээ удаан хугацаанд хадгалан үлдэх гэсэн зарчимтай гэсэн үг юм. Тэгэхээр үр ашигтай улс төрийн технологийг авч хэрэгжүүлсэнээр тодорхой улс төрийн орон зайд улс төрийн систем нь тогтвортой байхын зэрэгцээгээр улс төрийн үйл явцыг удирдах удирдлага нь үр ашигтай байдаг гэсэн үг юм. Улс төрийн технологи нь нийгмийн хөгжлийн хүрсэн түвшин, улс төрийн дэглэмийн шинж чанараас шалтгаалаад харилцан адилгүй хэв шинжүүдтэй байдаг.¹¹⁶

Нэг талаас улс төрийн хямралыг зохицуулах технологи гэдэг нь түүнийг шийдвэрлэх технологийн тухай асуудал юм. Харин нөгөө талаас биеэ даасан судлагдахуун болж байдаг.

Улс төрийн хямралыг зохицуулах технологийн тухай асуудал нь стратеги ба тактикийн асуудлыг агуулж байдаг. Өөрөөр хэлбэл улс төрийн хямралыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлж байгаа технологийн асуудлын цаана стратеги ба тактикийн арга хэмжээнүүд яригдаж байдаг гэсэн үг юм.

Улс төрийн хямралаас гарах арга замыг эрэлхийлэх нь түүнийг үүсэн бий болоход нөлөөлж байгаа хүчин зүйлийг олж тогтоон түүнтэй тэмцэнэ гэсэн үг юм.

¹¹⁶ Анохин М.Г. Политические технологии//Вестник Российского университета дружбы народов. Сер: Политология. 2002. №2. с. 103-104

Ерөнхийдөө улс төрийн хямралыг зохицуулна гэдэг нь түүнийг таслан зогсоох тухай асуудал юм. Тиймээс үүссэн хямралын нөхцөл байдлаас гарахын тулд хямрал үүсэхэд хүргэж байгаа хүчин зүйлийг олж тогтоохын тулд тухайн системийн гадаад болон дотоод орчинг сайтар шинжлэн үзэх шаардлагатай. Үүнээс үзэхэд аливаа системийн бүтцэд улс төрийн хямралын шалтгаан, түүнийг шийдвэрлэх технологийн асуудал нь давхар агуулагдаж байдаг гэсэн үг юм.¹¹⁷

Улс төрийн хямралын удирдлагын эхний шалгуур нь түүнд стратеги тактикийн шинж агуулагдаж байгаа эсэх юм. Харин түүний хоёр дахь шалгуур нь улс төрийн хямралыг шийдвэрлэхийн тулд авч хэрэгжүүлж байгаа технологийн арга хэмжээ хэрэгжихэд шаардлагатай мөнгө санхүү, хүн хүч, оюун санааны болон бусад нөөц бололцоо юм. Тиймээс улс төрийн хямралыг шийдвэрлэж зорилтот үр дүнд хүрэхийн тулд тухайн улс төрийн системд шаардлагатай нөөц байх ёстой. Харин улс төрийн хямралын технологийн амжилттай хэрэгжих гурав дахь үзүүлэлт бол цаг хугацааны асуудал юм. Улс төрийн хямрал нь зайлшгүй шинжтэй байдаг учраас улс төрийн системийн хувьд түүнийг тойрон гарч хөгжих боломжгүй юм. Улс төрийн хямралын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ ба бодлого нь тодорхой цаг хугацаанд л үр ашигтай байдаг ба хэрвээ тэрхүү цаг хугацаа нь өнгөрсөн л бол ямар ч бодлого, удирдлага үр ашигтай шинжээ алддаг. Тиймээс улс төрийн системийн хувьд хүссэн үр дүндээ хүрэх бодлого, үйл ажиллагаа нь түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц бололцоо ба хэрэгжих цаг хугацаагаар хэмжигддэг байна.

Улс төрийн хямралыг зохицуулахдаа дараахь элементүүдийг авч үзэх хэрэгтэй болно. Үүнд:

1. Хямралын шалтгааныг тогтоохдоо гадаад хүчин зүйлийг тооцоолох. Гадаад хүчин зүйлийг тооцоолно гэдэг нь үүссэн нөхцөл байдлын талаар олон нийт ямар хандлагатай байгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тодорхойлохыг хэлж байгаа юм. Иймээс нөхцөл байдлыг үнэлэхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин олон нийтэд хүрч байгаа мэдээ, мэдээллийн агуулгад тодорхой шаардлага тавих хэрэгтэй юм.¹¹⁸
2. Хямралын нөхцөл байдалд байгаа улс төрийн систем ба улс төрийн байгууллагын бүрдэлд дүн шинжилгээ хийх. Хямралд нөлөөлөх байгууллагын гадаад хүчин зүйлийг судалсан дүн шинжилгээн дээрээ тулгуурлан бодит нөхцөл байдлыг үнэлэх хэрэгтэй юм. Ингэснээр тухайн байгууллага ирээдүйд ямар дүр төрхтэйгээр оршин байхыг тооцоолох боломжтой болох ба улмаар энэ нь удирдлагад хямралын нөхцөл байдлаас хэрхэн амжилттай гарах хямралын эсрэг стратеги төлөвлөгөөг боловсруулах боломжийг олгодог гэсэн үг юм.
3. Өдөр тутам авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ үр ашигтай байдлыг тодорхойлох. Тухайн авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны үр ашигтай байх эсэх нь түүний үр дүнд хямралаас хэр зэрэг хурдан гарч байгаагаар тодорхойлогддог.
4. Системийг хүчтэй болгож байгаа үүний эсрэгээр хүчин мөхөс болгож байгаа шалтгаануудыг мөн байгууллагын давуу ба сул талыг тооцоолох. Тухайн системийн үйл ажиллагаанд SWOT дүн шинжилгээ хийх нь

¹¹⁷ Иванова Е.Н. Антикризисное управление в России/Е.Н. Иванова, С.А. Сулимов//Оценочная деятельность в России: Сб. Науч. Тр. М., Вып. 3. с. 170

¹¹⁸ Чекалкин В.И. Кризис в России: участники, итоги и перспективы//Власть. 1998. №10-11. с. 16-23

хямралын нөхцөл байдлыг даван туулах системийн чадварыг шалгаж байна гэсэн үг юм.

5. Системийг хямралд хүргэж байгаа асуудлыг олж тогтоох. Хямралд хүргээд байгаа асуудлыг томъёолохгүйгээр хямралын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжгүй юм.

Улс төрийн хямралыг амжилттай шийдвэрлэхэд дараахь гурван нөөц мөн хоёр баталгаат нөхцөл хэрэгтэй юм. Үүнд:

- Нэгдүгээр нөөц- бодлогыг хэрэгжүүлэхэд цаг хугацаа хангалттай байх
- Хоёрдугаар нөөц- Хямралын эсрэг удирдлагыг хэрэгжүүлж байгаа субъектэд бүрэн эрх хангалттай олгогдсон байх
- Гуравдугаар нөөц- бодлогыг сонгон авч хэрэгжүүлэхэд мөнгө, санхүү хангалттай байх

Нэгдүгээр баталгаат нөхцөл- Дээрх гурван нөөцийн аль нь ч тэгтэй тэнцүү утгыг заах ёсгүй.

Хоёрдугаар баталгаат нөхцөл- Дээрх гурван нөөцийн аль нэг нь хангалттай бус утгыг зааж байхад үлдсэн хоёр нь бүрэн хангалттай байх ёстой. Хэрвээ дээрх гурван нөөцийн аль нэг хоёр нь хангалттай бус байгаа тохиолдолд хямралын эсрэг бодлого үйл ажиллагааг хэрэгжүүлэх ямар ч боломжгүй болдог.¹¹⁹

Ихэнх тохиолдолд хямралын нөхцөл байдлаас гарах удирдлагын үйл ажиллагаа нь дараахь дарааллын дагуу өрнөдөг байна. Үүнд:

1. Системд учирч болохуйц аюулыг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлийн талаарх мэдээ, мэдээллийг цуглуулах;
2. Улс төрийн нөхцөл байдлыг үнэлэн, хямралыг үүсгэх боломж бүтцэд байгаа эсэхийг судлах;
3. Системийн хөгжлийн хэвийн үйл явцыг алдагдуулж байгаа дотоод хүчин зүйлд дүн шинжилгээ хийх;
4. Дээрх гурван үед хийсэн дүн шинжилгээн дээрээ тулгуурлан байгууллагын нөөц ба боломжийг олж тогтоох;
5. Хямралаас үүсэх чанарын өөрчлөлтийн үр дүнг саармагжуулах зорилгоор хямралын эсрэг анхны арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
6. Хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг үнэлэх;
7. Системийн үйл ажиллагааг ирээдүйд амжилтгүй болгох гадаад, дотоод хүчин зүйлийг илрүүлэх;
8. Үүссэн улс төрийн нөхцөл байдлыг засварлах.¹²⁰

Улс төрийн хямралын удирдлагын үйл явцад хамгийн чухал үе шат бол хямралын нөхцөл дэх улс төрийн шийдвэрийг авч хэрэгжүүлэх үе шат юм. А.А. Дегтярев, Г.Лассуэль, И.Дрор нар улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх онол гэдгийг гаргаж ирсэн байдаг. "Улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэх онол гэдэг нь улс төр эрхзүйн хэмжээ ба механизмын олон талт шинж байдал дээр тулгуурлан хүндрэлтэй нөхцөл байдалд төрийн удирдлагын үр ашигтай байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хангах улс төрийн удирдлагын тухай шинжлэх ухааны нэг хэсэг юм"¹²¹

¹¹⁹ Crisis management(краткий курс)//Советник. 1998. №9. с. 14

¹²⁰ Бобылева А.З. Методолгические основы управления организациями в кризисной ситуации.//Государственное управление, электронная вестник. 2003. №1//http://www.spa.msu.ru/e-journal/1/16_1.php

¹²¹ Дегтярев А.А. Теория принятия политических решений в структуре социальных и управленческих дисциплин //Полис. 2002. №2. с. 117

Шийдвэрийг хэрэгжүүлэх онол нь суурь болон хавсарга судалгааны шинжийг агуулж байдаг. М.Хиллийн тодорхойлсоноор улс төрийн удирдлагын үйл явцын талаарх судалгаа нь шийдвэрийг хэрэгжүүлэх онолын суурь судалгаа нь болдог.

Хямралын үед хамгийн чухал асуудал нь улс төрийн лидерүүдээс гарах улс төрийн шийдвэр байдаг. Хямралын үед массын олонх нь тухайн нөхцөл байдлаас гарах шийдвэрийг хэрэгжүүлэхийг удирдлагаас шаарддаг, харин тухайн шийдвэрийг авч хэрэгжүүлэх биелэлтийг хянах үүргийг цөөнх нь хүлээж байдаг байна.

Хямралын нөхцөл дэх улс төрийн шийдвэр ямар байх талаарх тодорхойлолтыг судлаач Серебрянник авч үзсэн байдаг. Тэрээр "Улс төрийн хүнд хэцүү нөхцөлд гаргах шийдвэр гэдэг нь тухайн харилцаанд оролцогч улс төрийн субъектүүдээс (дотоод ба гадаад улс төрийн субъект, үндэстний ба бүс нутгийн хэмжээний субъект, эрх баригч ба сөрөг хүчин гэх мэт) ихээхэн шалтгаалдаг. Үнэн хэрэгтээ тэр субъектүүд нь нэг бол нийгмийн янз бүрийн хөдөлгөөний болон улс төрийн намын эсхүл засаглалын хэрэгжүүлэгчдийн төлөөлөл байдаг юм. Тэгэхээр бүх хүмүүст хамаатай улс төрийн шийдвэр гарана гэдэг нь төрийн дээд удирдлагын хүрээнд хамааралтай асуудал болох нь харагдаж байгаа юм. Тиймээс аливаа улс орон Үндсэн хуулиндаа дайны болон онцгой байдал зарласан тохиолдолд авч хэрэгжүүлэх төрийн гадаад, дотоод бодлогын үндсээ тодорхойлсон байдаг. Харин тэрхүү шийдвэрийн биелэлтийг хангахад зайлшгүй шаардлагатай төрийн, эдийн засгийн, нийгмийн, мэдээллийн зэрэг нөөцийн эх үүсвэр хэрэгтэй бөгөөд энэхүү харилцааг зохицуулах эрхзүйн хэм хэмжээ ч чухал"¹²² гэж дүгнэсэн байдаг. Тухайн нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх улс төрийн шийдвэрийн агуулгат улс төрийн субьектийн болоод улс төрийн байгууллагуудын хувийн эрх ашиг тусгагдах хандлагатай байдаг бөгөөд энэ тохиолдолд хувийн гэхээсээ илүү нийтийн ашиг сонирхолын төлөө байх нь чухал юм.

Судлаач У.Юри, Р.Смоук нар хямралын нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх улс төрийн шийдвэрт нөлөөлөх дөрвөн хүчин зүйлийг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Оролцогчдын түвшин. Тухайн харилцаанд оролцогчдын хувьд үүссэн улс төрийн нөхцөл байдлыг ойлгож дүгнэж, хүлээж авах түвшин нь харилцан адилгүй байдаг.
2. Цаг хугацаа хүрэлцээгүй байх. Тухайн шийдвэрийг маш богино хугацаанд яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай байдгийн улмаас шийдвэрийг хянах, түүнд дүн шинжилгээ хийх цаг хугацаа бараг байдаггүй. Хямралын нөхцөл байдлын тухай анхны мэдээлэл нийгэмд хүрэхэд л түүнийг шийдвэрлэх улс төрийн шийдвэрийн эхний алхам хийгдэж эхэлсэн байх учиртай юм. Тиймээс ийм нөхцөл байдалд гаргаж байгаа улс төрийн шийдвэр бол яаралтай, хойшлуулашгүй шинжийг агуулсан байх ёстой. Зарим тохиолдолд тухайн улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд эрсдэлтэй алхамуудыг ч хийх болдог. Магадгүй энэ эрсдэлтэй алхамыг хийснээс зарим тохиолдолд улс төрийн лидерүүдийн байр суурь улам бүр баталгааждаг ч зарим тохиолдолд бүр үүний эсрэгээр улс төрийн байр сууриа алдах тохиолдол ч гардаг. Мөн тухайн шийдвэрийн биелэлтийг хангахад шаардлагатай нөөцийн эх сурвалж байхгүй аль эсхүл хүрэлцэхгүй тохиолдол ч байна.
3. Хямралын нөхцөл байдлын тодорхойгүй шинж төлөв. Хямралыг шийдвэрлэхэд талууд цаг хугацаа хангалттай бус байхын зэрэгцээгээр зорилгодоо хүрэх арга хэрэгсэл, үйл ажиллагааны төлөвлөгөөний талаарх мэдээлэллээ улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэхээр зорьж буй талууд бие

¹²² Серебрянников В.В. Принятия политических решений в экстремальных ситуациях//Власть. 2003. №2. с. 12

биенээсээ нууж байдаг. Өөрөөр хэлбэл тэр мэдээлэлд хүрэх боломж нь улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэгчдийн хувьд хязгаарлагдмал байдаг. Энэ байдал нь улс төрийн шийдвэрийг хэрэгжүүлэгч талуудын хувьд харилцан итгэлцэлд нь сөргөөр нөлөөлж улмаар хямралт нөхцөл байдлыг улам бүр тодорхойгүй болгож байдаг. Мөн нөгөө нэг асуудал нь бодит нөхцөл байдлын талаарх мэдээллийг эх сурвалжаас нь биш албан бус мэдээллийн сурвалжаар олж авах нь бас нөхцөл байдлын төлөвийг хурцатгахад хүрдэг. Үүссэн нөхцөл байдлаас улс төрийн ашиг хонжоо хайгчид аль ч нийгэмд байсаар л байгаа тохиолдолд бодит мэдээллийг хаан боогдуулах өөрсдийн эрх ашигт нийцүүлэн засварласан мэдээллийг нийгэмд цацах зэрэг нь иргэдийг улам бүр өдөөн турхирах, шийдвэрийг хэрэгжүүлэгчдэд үл итгэх байдлыг улам бүр нэмэгдүүлсээр байдаг. Иймээс хямралын нөхцөлд чухал үүрэгтэй салбар бол хэвлэл мэдээллийн салбар юм. Тиймээс үүссэн улс төрийн нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийн урсгалд хяналт тавих шаардлагатай юм.

4. Хямралын нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх улс төрийн шийдвэрийн сонголтот хувилбар хязгаарлагдмал байх. Нөхцөл байдалд үнэлгээ хийн түүнийг даван туулах шийдвэрийн талаар маш олон санаа байх боломжтой хэдий ч хямрал нь маш богино хугацаанд эрчимтэй өрнөдөг үйл явц учраас цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан улс төрийн шийдвэрийн олон хувилбарыг гаргаж ирэх боломжгүй байдаг.¹²³

Хямралын үед хэрэгжүүлэх улс төрийн шийдвэрийг тухайн нөхцөл байдлыг судлаж үнэлэн, түүний цаашдын хэрхэн өрнөх төлөв байдлыг тогтоосны үндсэн дээр гаргах ёстой гэсэн санааг судлаач А.С. Ахременко гаргаж ирсэн байдаг. Цаг хугацааны хувьд улс төрийн шийдвэрийг гаргахын өмнө тухайн шийдвэрт бэлдэх үе гэж байдаг бөгөөд энэ үед үүссэн улс төрийн нөхцөл байдалд эдийн засгийн болоод улс төрийн шинжлэх ухааны судалгааны хавсарга арга дээр суурилан шинжилгээ хийн үйл явцын ерөнхий дүр төрхийг гаргаж ирэх шаардлагатай юм. Өргөн утгаараа улс төрийн шийдвэрт дүн шинжилгээ (decision analysis) хийнэ гэдэг нь шийдвэрийг хэрэгжүүлэгчийн зүгээс үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг цуглуулан түүнд дүн шинжилгээ хийн нөхцөл байдлын талаарх ерөнхий зураглалыг хийх арга, үйл ажиллагаа юм. Гэхдээ энэ тохиолдолд дүн шинжилгээг шийдвэрийн сонголтот хувилбарыг нэмэгдүүлэхээр хийж байгаа биш юм. Энэхүү дүн шинжилгээ хийхийн гол зорилго нь шийдвэрийг хэрэгжүүлэгчийн тусламжтайгаар үүссэн хямралт нөхцөл байдлыг даван туулах илүү сайн арга олох явдал юм. Шийдвэрт дүн шинжилгээ хийж байгаа энэ тохиолдолд үүссэн нөхцлийн талаар заавал зөвлөмж зөвлөгөө гаргахдаа гол зорилго нь биш харин ч нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээлэл дээр тулгуурлан авч хэрэгжүүлэхээр зорьж буй улс төрийн шийдвэрт тулгарах эрсдэлийг бууруулах явдал байдаг юм.¹²⁴

Хямралын нөхцөлд улс төрийн шийдвэр гаргана гэдэг нь үүссэн нөхцөл байдлаас улс төрийн системийг авран түүнийг шинэ нөхцөл байдалд дасан зохицуулах үүрэгтэй улс төрийн үйл явцын салшгүй нэг хэсэг юм. Ийм нөхцөлд гаргаж байгаа улс төрийн шийдвэрийн зорилго нь хямралын нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нийгмийн аюулгүй байдлыг хангах, улс төрийн системийн дэг журам, тогтвортой байдлыг хадгалан үлдэх, нийгэм болоод улс төрийн

¹²³ Ury W., Smoke R. Beyond the hotline: Controlling the Nuclear Crisis. Cambridge, Harvard law school., 1984

¹²⁴ Ахременко А.С. Сценариотехника в аналитическом обеспечении процедуры принятия политических решений//<http://pr.philos.msu.ru/ahr3.html>

амьдралд үүссэн түгшүүрийг арилгах явдал юм.¹²⁵ Үүнээс үзэхэд хямралын нөхцөлд авч хэрэгжүүлэх улс төрийн шийдвэрийн хамгийн гол зорилтот асуудал нь хямралыг зохицуулах түүнийг амжилттай шийдвэрлэх явдал юм.

Хямралын нөхцөл дэх мэдээллийн урсгалын тодорхой бус байдал нь хямралыг улам бүр гүнзгийрүүлэх хандлагатай байдаг. Мэдээллийн ихэнх хэсэг нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийн дамжин цацагддаг учраас маш хурдан тархдаг. Хямралыг шийдвэрлэх стратегийн хүрээнд мэдээллийн дээрх үйл явцыг хянах үйл ажиллагаа нь түүний салшгүй нэг хэсэг байх ёстой юм.

Эдийн засгийн хямралыг шийдвэрлэхийн тулд зөвхөн эдийн засгийн арга хэрэгслийн тусламжтайгаар үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийдэг бол улс төрд бол яг ийм тогтсон хандлага байдаггүй байна. Улс төрийн хямралын талаар мэргэшсэн судлаачид улс төрийн хямрал нь ямагт олны анхаарлын төвд байдгийг дараах онцлог шинжүүдээр нь дамжуулан тайлбарласан байдаг. Үүнд:

1. Гэнэтийн шинж. Улс төрийн хямрал нь хөгжлийн тодорхой үе шатанд үүсдэг гэж үздэг боловч гэнэт гарч ирдэг улс төрийн үйл явц юм.
2. Мэдээллийн хүрэлцээтэй бус байдал. Хямралын үр дүнд хүсэн хүлээгээгүй олон үр дагавар үүсдэг бөгөөд зарим нэг талаараа энэ байдал нь үүссэн нөхцөл байдлын талаарх үнэн зөв мэдээлэл хүрэлцээтэй бус байдагтай холбоотой хэмээн үздэг.
3. Зөвхөн нэг хэлбэрээр өрнөдөг хөдөлгөөнгүй үйл явц биш. Улс төрийн хямрал нь өрнөлтийнхээ хугацаанд олон хэлбэрт шилжиж байдаг. Тиймээс түүнийг шийдвэрлэх арга, технологи, авч хэрэгжүүлэх улс төрийн шийдвэр нь тогтсон нэг хэлбэрийнх байх боломжгүй бөгөөд нөхцөл байдлаа дагаад хувиран өөрчлөгдөж байдаг динамик шинжтэй юм.
4. Хяналтыг алдагдуулдаг. Үүсэн нөхцөл байдлын хүндрэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа бодит бус мэдээлэл зэрэг нь нөхцөл байдлын хяналтыг алдагдуулдаг.
5. Гадны хүчний оролцоотойгоор өрнөдөг. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөөгөөр үүссэн нөхцөл байдал илүү хүндрэх аль эсхүл намжих тал ч бий.
6. Үүссэн нөхцөл байдлын талаарх ихэнх нь ташаа бодолтой байдаг. Хямралын нөхцөл байдалд л аливаа бүтэц өөрийгөө мэдрэх мэдрэмж нь бий болдог. Нэг талаас эргэн тойрон бүслэлтэнд орсон юм шиг нөхцөл байдал нь бүтцэд өөрийгөө илүү мэдрэх, таньж мэдэх боломжийг олгодог байна. Тиймээс л хэргийн газар дээр ирсэн мөрдөгчид сэжигтэнд "Та үг хэлэх эрхтэй, гэхдээ таны хэлсэн болгон таны эсрэг ашиглагдах боломжтой учраас та бас дуугүй байх эрхтэй хэмээн хэлдэг" юм гэж хуульчид тайлбарласан байдаг.¹²⁶

Мөн хямралын үед авч хэрэгжүүлэх улс төрийн бодлого шийдвэр ямар байх талаар судлахын зэрэгцээгээр хямралын үе дэх коммуникацийн талаар авч үзэх хэрэгтэй юм. Учир нь хямралын дараа шинээр үүсэх нөхцөл байдал нь хямралын үе дэх коммуникациас ихээхэн шалтгаалдаг байна. Хямралын нөхцөл байдалд үйл явцын талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийгэмд хүргэх нь нэг талаасаа сайшаалтай хэдий ч нөгөө талаасаа дээр дурьдсанчлан хямралын нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлэх сөрөг үр дагавартай

¹²⁵ Серебрянников В.В. Принятия политических решений в экстремальных ситуациях//Россия в условиях трансформаций:Материалы историко-политического семинара. Выпуск 26. М., 2003. с. 9

¹²⁶ Seitel F.P. Communication in Crisis//United States Banker. 1990. №21. December. p. 49

байдаг болохоор нийгэмд хүрж байгаа мэдээллийн урсгалд тодорхой хэмжээний хяналт тавьж байх нь хэрэгжүүлэхээр зорьж буй улс төрийн шийдвэрийн биелэлтэнд ихээхэн ач холбогдолтой байдаг. Зарим тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь улс төрийн намын харъяаллаар мэдээ, мэдээллийн үнэ цэнд хандаж, зөвхөн намын эрх ашигийн үүднээс тайлбар хийх улмаар зөвхөн нэг талыг дэмжин сайшаах, үүний эсрэгээр нөгөө талыг заавал буруутай мэтээр тайлбарласан мэдээллийг нийгэмд цацах нь улс төрийн хямралыг үр дүнтэйгээр шийдвэрлэх боломжийг хааж байдаг. Магадгүй зарим тохиолдолд зөвхөн хэсэг бүлэг хүмүүсийн хоорондын үзэл бодлын зөрчилдөөн, ашигийн төлөөх тэмцэл нь тэнцвэргүй, шударга бус, худал мэдээллийн улмаас системийн түвшинд шийдвэрлэгдэх улс төрийн хямрал болтлоо өөрчлөгддөг байна. Тэгэхээр мэдээ мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь улс төрийн хямралыг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй хэдий ч буруу мэдээлэл, түүний урсгал нь хямралын нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байдаг гэдгийг авч үзэх хэрэгтэй болж байгаа юм. Тиймээс үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээлэл нь бодит зүйл дээр суурилсан байх шаардлагатай байдаг гэдэг нь үүнээс харагдаж байна. Хямралын үед олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл дараахь алдаануудыг гаргадаг байна. Үүнд:

1. Мэдээний агуулгад бодлогогүй ханддаг. Тухайн нөхцөл байдлын үнэн төрхийг илэрхийлэхээс илүү хэрхэн яаж олон түмэнд сонирхолтой байлгах вэ гэдэг бизнесийн ашиг хонжоо хайдаг явдал нь мэдээний агуулгыг гуйвуулах, хувийн чиг баримжаагаар хандах хандлагыг бий болгодог байна.
2. Шударга бус зүйлийн тухай аливаа яриа нь үүссэн нөхцөл байдлын бодит байдлыг улам бүр бүдэгрүүлж байдаг. Хямралын нөхцөл байдал нь нийгмийг эмх замбараагүй байдалд хүргэж тэр хэрээрээ нийгэмд шударга бус зүйл гарахад нөлөөлж байдаг. Гэтэл үүний зэрэгцээгээр шударга ёс нийгэмд байсаар байгаа гэдгийг авч үзэхээсээ өмнө бусдын анхаарлыг татах зорилгоор шударга бус зүйлийн талаар байнга дамжуулах нь массад үүссэн нөхцлийн талаар сөрөг чиг хандлага төлөвшихөд ихээхэн нөлөөлдөг байна. Мөн нөгөөтэйгүүр хямрал бол шударга зүйлийг шударга бус байдлаас ялгах томоохон боломжийг олгож байдаг.
3. Үүссэн нөхцөл байдлыг тод томруун харуулах гээд хэтэрхий нарийвчлан мэдээлдэг. Энэ нь хямралын улмаас үүсэх сөрөг үр дагаврыг бууруулахаас илүү нөхцөл байдлыг улам бүр хурцатгаж байдаг.
4. Хямралын нөхцөл байдлын талаарх шинэ мэдээллийг түрүүлж олж мэдэх гэсэн эрмэлзэл. Хэн ч үнэнийг өөрчилж чадахгүй учраас эрт орой хэзээ нэгэн цагт үнэнийг олж мэдэх нь тодорхой юм. Үнэн бодит зүйлийн талаар түрүүлж олж мэдсэнээр хямралыг түргэн хугацаанд шийдвэрлэх боломжтой болдгийн биш харин ч шинэ мэдээлэл нь шинэ нөхцлийг бий болгохоос өөр зүйлгүй байдаг.
5. Хямралын үед харилцан зөрчилдсөн утга агуулгатай мэдээллийг цацаж байдаг.

Хямралын үед олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн гол зорилго нь тухайн нөхцөл байдлаас үүсэх сөрөг үр дагаврыг багасгах, хямралын түвшинг бууруулахад чиглэсэн мэдээ мэдээллийг нийгэмд түгээх бөгөөд ингэхийн тулд хямралыг өдөөх шинж чанартай мэдээллээс илүү түүнийг нийгмийн хөгжлийн нэг үр дагавар учраас гэнэт үүсэн гарч ирсэн шиг түүнийг шийдвэрлэн зогсоох арга технологи байдаг гэдгийг тайлбарлан таниулах хэрэгтэй юм. Аливаа гарцгүй буюу шийдэлгүй зүйл л нийгмийг мухардалд оруулдаг. Тэгвэл хямралд гарц ба шийдэл гэж байдаг учраас тухайн системийн хувьд энэ бол түр зуурын бэрхшээл болохыг

нийгмээрээ ойлгон ухаарах нь түүнийг гэтлэн давах үйл явцыг илүү хурдасгаж, хялбаршуулах боломжийг бүрдүүлж байдаг. Мэдээж энэ үйл явцад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг чухал болох нь тодорхой юм.

Гэхдээ үүссэн хүндрэлтэй нөхцөл байдал бүрийг хямрал гэж ойлгох боломжгүй юм. Нийгэмд хэлбэр, үр дагаврын хувьд хямралтай төстэй нөхцөл байдлууд олноороо үүсч байдаг. Ийм нөхцөл байдлыг хуурмаг хямрал хэмээн нэрлэдэг. Иймээс хямралын нөхцөл байдлыг хуурмаг хямралаас ялган авч үзэх хэрэгтэй юм. Судлаач А. Чернозатонский хуурмаг хямралыг хямралын нөхцөл байдлаас ялгарах ялгааг дараахь байдлаар авч үзсэн байдаг. Үүнд:

1. Хуурмаг хямралын дараагаар нөхцөл байдал маш хурдан хувиран өөрчлөгддөг. Урьдчилан тааварлах боломжгүй олон алхамууд нэгэн зэрэг гарч ирж байдаг.
2. Оролцогчдын тоо улам бүр өссөөр байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин цацагдаж байгаа мэдээ, мэдээллийн агуулгаас шалтгаалан тохиолдлын байдлаар тухайн нөхцөл байдалд татагдан орох оролцогчдын тоо нэмэгдсээр байдаг.
3. Үүссэн нөхцөл байдлын талаарх гадаад орчноос ирж байгаа мэдээлэл нь нөхцөл байдалтайгаа таардаггүй таамаглалын шинжтэй байдаг.
4. Санхүүгийн гэнэтийн алдагдалд ордог.
5. Хий хөөрсөн хошуучлагчдын тоо улам бүр олширдог. Гэтэл олон түмнээр хүлээн зөвшөөрөгдөөгүй, нийгэм хүсэн хүлээж байгаагүй хошуучлагчид, тэдний үйл ажиллагаа нь бодлогын үр ашигтай байдалд сөргөөр нөлөөлдөг.¹²⁷

Хямралын үе дэх коммуникацийн хамгийн чухал зүйл нь тохиолдсон зүйл бүрийн талаар мэдээлэхээс татгалзах явдал юм. Хямралын үед олон нийтийн мэдээллийн хэрэгсэл үр ашигтай байхын тулд үйл явдлын төвд байж, мэдээллийн хувьд нээлттэй чөлөөтэй байхын зэрэгцээгээр хэт нэг талын үзэл баримтлалыг даган туйлшрахгүй төвийг сахисан байр суурийг баримтлах ёстой юм. Гэвч нөгөө талаас олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд ажиллаж байгаа ажилтан ажиллагсадын мэргэжлийн ур чадвар, туршлага их чухал байдаг. Жишээ нь: телевизор, радиогийн хувьд нөхцөл байдлын талаарх шуурхай мэдээллийг туршлагагүй шинэ нэвтрүүлэгчээр хөтлүүлэх нь тэр мэдээллийг хүлээн авч байгаа үзэгчид буруу сэтгэгдэл төрүүлэхээс эхлүүлээд маш олон сөрөг үр дагаврыг бий болгодог гэж үздэг. Учир нь тэдэнд туршлага байхгүйн улмаас мэдээ мэдээллийг унших дуун хоолойн өнгөөс эхлээд нүүрний хувирал зэрэг нь үзэгчдэд шууд сөргөөр нөлөөлдөг байна. Хямралын үед хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг нь нийгэмд үүссэн зовнилыг арилгаж тайван байдлыг хангах явдал юм. Тиймээс хямралын нөхцөл дэх хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүлээх үүргийг дараахь байдлаар томъёолсон байдаг. Үүнд:

1. Хямралыг зогсоохын тулд нөхцөл байдлын талаарх үнэн зөв мэдээллийг аажмаар олон нийтэд түгээх ёстой
2. Мэдээллийн агуулга нь хямралаас үүсэх хор хохирлыг бууруулахад чиглэсэн байх ёстой.
3. Нийгэмд, хувь хүнд өөртөө итгэх итгэлийг төрүүлдэг байх ёстой.

Хямралын нөхцөл дэх мэдээллийн бодлого нь улс төрийн хямралыг шийдвэрлэхэд нөлөөлөх чухал хүчин зүйл болж байдаг. Мэдээллийн бодлого нь хямрал үүссэн эхний өдрөөс эхлээд хямрал дуусч нийгэм тайван байдалд орох

¹²⁷ Чернозатонский А. Антикризисный PR в политике

// <http://pr-liga.org.ua/2/33/77/0/0?PHPSESSID=fa6b8f2b912ce4936a66a0448cc3a6a0>

сүүлийн өдөр хүртэл хямралыг шийдвэрлэх технологийн асуудлын салшгүй нэг бүрдэл байсаар байдаг байна.

Дүгнэлт

Эндээс үзэхэд хямрал гэдэг нь улс төр, эдийн засаг, социологи, олон улсын харилцаа, сэтгэл судлал гэх мэт олон шинжлэх ухааны уулзварт орших олон талт ойлголт болох нь харагдаж байна. Хямралын талаарх улс төр, социологийн шинжлэх ухаанд хийгдсэн судалгаа шинжилгээний ажил нь олон улсын харилцаа болон бусад шинжлэх ухааны салбаруудад хийгдсэн судалгаануудтай харьцуулахад онолын шинжийг илүү их агуулсан байдаг. Харин хямралын нөхцөл байдлыг удирдлагаар хангах, түүний төлөв байдлыг хэрхэн таамгалах талаарх судалгаа шинжилгээний ажил эдийн засгийн салбарт харьцангуй ихээр хийгдсэн байдаг бөгөөд энэ салбарт одоо ч судлагдсаар л байна.

Улс төрийн хямралыг шийдвэрлэх, түүнийг зохицуулах нь хямралын эсрэг удирдлага, эрсдэлийн удирдлагын хүрээнд гарч ирсэн ойлголт юм. Улс төрийн хямралын эсрэг удирдлага гэдэг нь үүсчихсэн хямралыг хэрхэн зохицуулах удирдлагын тухай асуудал гэж ойлгохоос илүүтэйгээр хямрал үүсэхээс өмнө тухайн улс төрийн системд хямралыг эсэргүүцэх түүнийг даван туулах дархлааг суулгах явдал гэж ойлгох нь зүйтэй юм. Тиймээс улс төрийн хямралын эсрэг удирдлага гэдэг нь дан ганц улс төрийн шинжлэх ухааны хүрээнд яригдах зүйл биш юм. Харин ч улс төрийн системд хямралыг эсэргүүцэх, түүнийг даван туулах дархлааг суулгахын тулд цаг хугацаа, нөөц боломж, дотоод эрмэлзэл бүгд хэрэгтэй учраас улс төрийн хямралын эсрэг удирдлага нь улс төрийн төдийгүй нийгэм, эдийн засаг, сэтгэл зүй гэх мэт олон шинжлэх ухааны судлагдахуун болж байна. Тэгэхээр улс төрийн хямралын эсрэг удирдлагыг хэрэгжүүлэх нь улс төрийн системээс тодорхой цаг хугацаа, эдийн засгийн нөөц боломж, түүнийг даван туулах гэсэн эрмэлзэл, төлөв байдлыг шаарддаг гэсэн үг юм.

Улс төрийн хямралын эсрэг удирдлага нь стратеги тактикийн хэсэг болон хямралын нөхцөлд хэрэгжүүлэх улс төрийн шийдвэр, хямралын эсрэг хэвлэл мэдээллийн бодлого гэсэн бүтэцтэй байдаг. Эдгээр бүтэц нь хямралыг зохицуулахад чухал үүргийг гүйцэтгэдэг учраас тодорхой хэм хэмжээтэй байдаг. Улс төрийн систем хямралын нөхцөлд амжилттай бэлтгэгдэн дээрх үндсэн гурван бүтэц нь хязгаарлагдмал нөөц боломж ба цаг хугацаанд үүргээ бүрэн гүйцэтгэж чадахаар болсон тохиолдолд улс төрийн систем хямралыг эсэргүүцэх бүрэн чадвартай болж улмаар улс төрийн хямралын эсрэг удирдлага зорилгодоо хүрч байна гэсэн үг юм.

Резюме

Урегулирование политических кризисов является ключевым понятием данного исследования. Предлагаются четкие ограничения между понятиями кризисного и антикризисного управления, риск менеджмента и управления конфликтами. Антикризисное политическое урегулирование имеет более политологическую окраску, чем другие понятия, кроме того, оно четко детерминировано во времени и является либо реакцией на уже произошедший кризис либо урегулирование начинается с ситуации предкризисной. Тем не менее, многие механизмы и методы из экономики применимы и работают в политике. Урегулирования политических кризисов зачастую

предшествует их разрешению, и, хотя эти понятия разграничены между собой, следует рассматривать их в связке и без отрыва друг от друга.

В структуре этого процесса выделяются: стратегия и тактика, принятие политических решений в кризисных ситуациях и антикризисная информационная политика. Все эти три составляющих имеют наиважнейшее значение, так как они отвечают условиям, необходимым для урегулирования кризисов. Главный критерий успеха - это быть подготовленными к кризисной ситуации, и при этом все эти три компонента смогут заработать в режиме ограничения ресурсов.

Ном зүй

1. Анатомия кризисов/ А.Д. Арманд, Д.И. Люри, В.В. Жерихин и др. М., 1999.
2. Антикризисный менеджмент. Превентивные методы управления / А.Б.Крутик, А.И.Муравьев. . 2001.
3. Барсамов В.А. Политические кризисы и смуты (История, теория, современность). М.: МИИТ, 1996.
4. Барсамов В.А. Структура общественно-политического кризиса (теоретический и прикладной анализ). М., 2002.
5. Безопасность Евразии 2002: Энциклопедический словарь-ежегодник/Автор Идеи и Концепции, Руководитель Проекта В.Н. Кузнецов. -М., 2003
6. Binder L., Pye L. et al. Crises and Sequences in Political Development. Princeton: Princeton University Press, 1971.
7. Boin A. Politics of Crisis Management / A. Boin, P. Flart, E. Stern, B.Sundelius - Cambridge: Cambridge University Press, 2006.
8. Chase W.H. Issue Management: Origins of the Future. - Stanford: Issue Action Publications, Inc., 1984.
9. Deutsch K.W. Social Mobilization and Political Development // American Political Science Review. N.Y., 1961.
10. Galtung J. The True Worlds: A Transitional Perspectives. N.Y.: Free Press, 1980.
11. Green P.S. Winning PR Tactics. Effective Techniques to Boost Your Sales. L.: Financial Times; Prentice Hall Books, 1994.